

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

Төрийн тусгай хамгаалалтын газар

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.2."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.3."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.2."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.3."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

5.2.Үнэлэлт, дүгнэлт

5.3.Зөвлөмж

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь шинэчилсэн найруулгын төслийн хувилбар байдлаар боловсруулагдсан болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Үрьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгахад чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, тодорхой байх, нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээний холбогдох заалтад нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “Практикт хэрэгжих боломж” болон “Зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм. Төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг Төрийн тусгай хамгаалалтын газар нь 1995 онд байгуулгдсан, хуулийн төслөөр тус байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт ороогүй тул практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцохоор шийдвэрлэсэн тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг сонгоогүй болно.

**ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ
ТОГТООСОН БАЙДАЛ**

3.1.“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн үндсэн зорилго	Үндсэн зорилгыг хангах зорилт	Зорилгыг хангахад чиглэгдсэн хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт
Хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүлэх чиглэлээр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг шинэчлэн найруулах	1.Төрийн тусгай хамгаалалтыг зорилго, хамрах хүрээ, хамгаалалтын арга хэмбэр болон баримтлах зарчим зэргийг харилцан уялдаатай байдлаар төрийн бусад хамгаалалтаас ялган тодорхойлж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгана.	<p>4 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зарчим</p> <p>4.1.Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:</p> <p>4.1.1.хууль дээдлэх;</p> <p>4.1.2.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;</p> <p>4.1.3.улс төрөөс ангид байх;</p> <p>4.1.4.нууцыг чанд хадгалах;</p> <p>4.1.5.иж бүрэн байх;</p> <p>4.1.6.тасралтгүй байх;</p> <p>4.1.7.шинжлэх ухааны болон орчин үеийн техник, технологийн ололтыг ашиглах;</p> <p>4.1.8.хамтран ажиллах.</p> <p>5 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалт</p> <p>5.1.Төрийн тусгай хамгаалалт нь хамгаалуулагч болон хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж байгаа эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хамгаалалт, үйлчилгээ, техник, технологийн болон бусад арга хэмжээний цогц байна.</p> <p>5.2.Төрийн тусгай хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд төрийн хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагын хэвийн, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг хангахад чиглэсэн тусгай албаны үйл ажиллагаа мөн.</p> <p>5.3.Төрийн тусгай хамгаалалтыг ил болон далд хэлбэр, тусгай арга, хэрэгслээр зохион байгуулна.</p>
	2.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тусгай албаны хувьд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг шинэчилж, хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбар болон төрийн байгууллага хооронд уялдуулан зохицуулах чиг үүргийг	<p>18 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллага</p> <p>18.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлнэ.</p> <p>18.2.Төрийн бусад байгууллагууд чиг үүрэг, энэ хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж оролцно.</p> <p>27 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын бүрэн эрх</p> <p>27.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>27.1.1.төрийн тусгай хамгаалалтыг зохион</p>

	<p>тусган өргөжүүлж, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хуульчилна</p> <p>байгуулах;</p> <p>27.1.2.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;</p> <p>27.1.3.төрийн тусгай хамгаалалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;</p> <p>27.1.4.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр арга зүйгээр хангах, чиглүүлэх, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>27.1.5.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;</p> <p>27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, дүн шинжилгээ хийх;</p> <p>27.1.7.төр, орон нутгийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;</p> <p>27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;</p> <p>27.1.9.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхдээ тухайн аюулгүй байдлыг хангах нөхцөл, хэрэгцээ, шаардлагыг харгалзан энэ хуульд заасны дагуу төрийн тусгай хамгаалалтын бус, хамгаалалтын дэглэм тогтоох, хяналт тавих;</p> <p>27.1.10.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;</p> <p>27.1.11.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгالت хийхэд алба хаагчаа байлцуулах;</p> <p>27.1.12.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;</p> <p>27.1.13.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бусэд радио холбооны сүлжээ сарниулах,</p>
--	---

		<p>радио төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсох;</p> <p>27.1.14.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэрээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан ажиллах;</p> <p>27.1.15.төрийн байгууллагын төвлөрсөн болон бусад мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;</p> <p>27.1.16.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг далдлахын тулд өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;</p> <p>27.1.17.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;</p> <p>27.1.18.гадаад орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;</p> <p>27.1.19.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;</p> <p>27.1.20.хуульд заасан бусад.</p>
	<p>3.Төрийн тусгай хамгаалалтад байх этгээд, объектыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн хуульчилна.</p>	<p>6 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, хүн, хамгаалалтад байх хугацаа</p> <p>6.1.Дараах албан тушаалтан, хүн төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>6.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;</p> <p>6.1.2.Монгол Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч;</p> <p>6.1.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч;</p> <p>6.1.4.Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч;</p> <p>6.1.5.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүн;</p> <p>6.1.6.Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, парламентын дарга, тэдгээрийг дагалдан яваа эхнэр /нөхөр/;</p> <p>6.1.7.Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад орны дэд ерөнхийлөгч, гадаад хэргийн сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, гадаад улсын төр, засгийн газрын тэргүүний бие төлөөлөгч, гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнж.</p> <p>10 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх объект</p> <p>10.1.Дараах хуралдаан төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>10.1.1.Улсын Их Хурлын чуулганы</p>

		<p>хуралдаан;</p> <p>10.1.2.Засгийн газрын хуралдаан;</p> <p>10.1.3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан.</p> <p>10.2.Доор дурдсан барилга байгууламж, нутаг дэвсгэр төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>10.2.1.Монгол Улсын Төрийн ордон;</p> <p>10.2.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын ажлын байр, зориулалтын орон сууц, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр;</p> <p>10.2.3.төрийн тусгай хамгаалалтын зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа барилга байгууламж, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр.</p> <p>10.3.Хамгаалуулагчийн хөлөглөн яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэл төрийн тусгай хамгаалалтад байна.</p> <p>10.4.Олон улсын дээд хэмжээний хурал, уулзалт, хэлэлцээг төрийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Засгийн газар тухай бүр шийдвэрлэнэ.</p> <p>10.5.Энэ хуульд зааснаас бусад объектыг төрийн тусгай хамгаалалтад авах, хамгаалалтаас гаргах асуудлыг энэ хуулийн 5.2-т заасныг болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.</p>
	4."Төрийн тусгай хамгаалалтын бүс"-ийг албан тушаалтан, хүн, барилга, байгууламж, хуралдаан зэрэг хамгаалалтын объектын онцлогийг харгалzan ялгамжтай байдлаар тогтоож хуульчилна.	<p>11 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын бүс</p> <p>11.1.Хамгаалуулагчийн болон төрийн тусгай хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын бүс тогтооно.</p> <p>11.2.Төрийн тусгай хамгаалалтын бүс байнгын болон түр байна.</p> <p>11.3.Төрийн тусгай хамгаалалтын байнгын бүсийг дараах байдлаар тогтооно:</p> <p>11.3.1.энэ хуулийн 10.1, 10.5-д заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага;</p> <p>11.3.2.энэ хуулийн 10.2-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг тухайн объектод хамаарах нутаг дэвсгэрийн хязгаараар;</p> <p>11.4.Төрийн тусгай хамгаалалтын түр бүсийг дараах байдлаар тогтооно:</p> <p>11.4.1.энэ хуулийн 7.4-т заасан барилга байгууламж, орон байр, нутаг дэвсгэрийн төрийн тусгай хамгаалалтын бүсийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч;</p> <p>11.4.2.энэ хуулийн 10.4-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага.</p>
	5.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, төрийн бусад байгууллага, хуулийн	<p>18 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллага</p> <p>18.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлнэ.</p> <p>18.2.Төрийн бусад байгууллагууд чиг үүрэг,</p>

	<p>этгээд, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг шинэчилнэ</p>	<p>энэ хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж оролцно.</p> <p>21 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын үүрэг</p> <p>21.1.Төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйлийг галын аюулаас хамгаалж, гамшиг, онцгой байдлын үед Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй.</p> <p>21.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>21.3.Онцгой байдлын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.</p> <p>22 дугаар зүйл.Эрүүл мэндийн байгууллагын үүрэг</p> <p>22.1.Хамгаалуулагчийн эрүүл мэндийг онцлон хамгаалах үүрэгтэй.</p> <p>22.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.</p> <p>22.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.</p> <p>23 дугаар зүйл.Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг</p> <p>23.1.Хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчинд болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг тогтмол тавьж, Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр лабораторийн шинжилгээ хийх бөгөөд холбогдох мэдээ, мэдээллээр Төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг шуурхай хангах үүрэгтэй.</p> <p>23.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллана.</p> <p>23.3.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.</p> <p>25 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд хүний хүлээх үүрэг</p> <p>25.1.Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хуульд нийцүүлэн тавьсан хүсэлт, шаардлагыг биелүүлж, бүхий л бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.</p>
	<p>6.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон</p>	<p>33 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч</p> <p>33.1.Энэ хуульд заасан тангараг өргөж, төрийн тусгай хамгаалалтын албанад томилогдон ажиллаж байгаа төрийн тусгай албан хаагчийг төрийн тусгай хамгаалалтын</p>

	<p>зохицуулалтыг улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах эрх зүйн үндэслэлийг тогтооно.</p>	<p>алба хаагч гэнэ.</p> <p>33.2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд тавигдах тусгайсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, төрийн тусгай хамгаалалтын албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ.</p> <p>33.3. Төрийн тусгай хамгаалалтын албанд ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тогтооно.</p> <p>40 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн баталгаа</p> <p>40.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хэлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшилаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.</p> <p>41 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн улс төрийн баталгаа</p> <p>41.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.</p> <p>41.2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг энэ хуулийн 41.1-д заасан үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.</p> <p>42 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хууль зүйн баталгаа</p> <p>42.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг шууд удирдах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, албан үүргээ гүйцэтгэж байхад нь саатуулах, бие, эд зүйлд нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.</p> <p>42.2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг албан тушаалын чиг үүрэгт нь нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.</p> <p>42.3. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргад мэдэгдэнэ.</p> <p>42.4. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Монгол Улсын Ерөнхий сайдад, бусад алба хаагчийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын</p>
--	---	--

	<p>даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.</p> <p>42.5.Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.</p> <p>42.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэнээс бусдад учирсан хохирлыг төр хариуцна.</p> <p>42.7.Эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, үүрэг даалгаврыг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ёсчлон биелүүлснээс үүссэн үр дагаврыг тушаал, үүрэг даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.</p> <p>42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.</p> <p>42.9.Энэ хуулийн 42.8-д зааснаас гадна дор дурдсан нөхцлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:</p> <p>42.9.1.байгууллагын захиалгаар дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцах;</p> <p>42.9.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох.</p> <p>42.10.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул занал учирсан, эсхул учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцна.</p> <p>42.11.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг гүйцэтгэх ажлын зорилгоор ашиглахыг хориглоно.</p> <p>42.12.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгднө.</p> <p>43 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаа</p> <p>43.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг түүний гэр бүлд нэг удаа олгоно.</p> <p>43.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад гэмт халдлагын улмаас эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэний урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан амь насанд нь хохирол учруулсны улмаас нас барсан бол энэ хуулийн 43.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.</p> <p>43.3.Энэ хуулийн 43.1-д заасан тэтгэмжийн зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нэхэн төлүүлнэ.</p> <p>43.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид</p>
--	---

	<p>заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно:</p> <p>43.4.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;</p> <p>43.4.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;</p> <p>43.4.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.</p> <p>43.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрт энэ зүйлийн 43.4.3-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.</p> <p>43.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>43.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.</p> <p>43.8.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.</p> <p>43.9.Энэ хуулийн 43.4-т заасан нөхөх олговор, тусламж олгох журам, 43.8-д заасан зардал олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>43.10.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтын албанд ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.</p> <p>44 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эдийн засгийн баталгаа</p> <p>44.1.Засгийн газар төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>44.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг төрөөс орон сууцаар хангана.</p> <p>44.3.Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжинд ажиллах үед хоол, унааны зардал, хээрийн сургууль, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.</p> <p>44.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд суралцагч төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн суралцах хугацааны сургалтын зардал, ирэх, буцах</p>
--	---

		<p>тээврийн зардлыг төр хариуцна.</p> <p>44.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс нь дараах цалин, нэмэгдлээс бүрдэнэ:</p> <p>44.5.1.албан тушаалын үндсэн цалин;</p> <p>44.5.2.цэргийн цолны цалин;</p> <p>44.5.3.төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл;</p> <p>44.5.4.албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл;</p> <p>44.5.5.мэргэшлийн зэргийн нэмэгдэл;</p> <p>44.5.6.эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл;</p> <p>44.5.7.хуульд заасан бусад.</p> <p>44.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн тусгай алба хаасан хугацааны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>44.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цэргийн цолны цалингийн хувь хэмжээг цэргийн цолны цалингийн хэмжээ тогтоосон хууль тогтоомжид зааснаар тооцно.</p>
	<p>7.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр "төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, алба хаах насын дээд хязгаарыг тогтоох, цэргийн цол хэрэглэх"-тэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж дүгнэсний дагуу хуулийн зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн шинэчилж, хууль хоорондын хийдэл, цоорхойг арилгана.</p>	<p>35 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, албаны үнэмлэх</p> <p>35.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.</p> <p>35.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загвар, өмсөх дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.</p> <p>35.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад цэргийн цол хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг энэ хуульд тусгайллан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.</p> <p>36 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах нас</p> <p>36.1.Ажлын шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан энэ хуульд заасан шаардлагыг хангасан 35 хүртэлх насын иргэнийг төрийн тусгай хамгаалалтын албананд томилж цэргийн цол олгож болно.</p> <p>36.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насын дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хуульд заасан ахлагчийн болон офицерийн алба хаах насын дээд хязгаартай адилтган тооцно.</p> <p>36.3.Алба хаах насын дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.</p>

	<p>36.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насны дээд хязгаарт Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны хязгаар хамаарахгүй.</p> <p>39 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавих ёс зүйн тусгай шаардлага</p> <p>39.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрийг бусад алба хаагч биелүүлэх үүрэгтэй. Удирдах албан тушаалтны шийдвэр хууль тогтоомж болон энэ хуулийн 39.2-т нийцсэн байна.</p> <p>39.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараах зүйлийг хориглоно:</p> <p>39.2.1.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах;</p> <p>39.2.2.албан тушаал, байгууллагын нэр болон хамгаалуулагчийн нэр төрийг хувийн болон улс төрийн зорилгоор ашиглах;</p> <p>39.2.3.хамгаалуулагч, түүний гэр бүл, дотны хүмүүст хувийн хүсэлт тавих, бусдын хүсэлтийг дамжуулах;</p> <p>39.2.4.албан үүргээ гүйцэтгэх болон албаны бэлэн байдал зарласан үед, ажлын байранд болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;</p> <p>39.2.5.мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;</p> <p>39.2.6.хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хэвлэн нийтлэх;</p> <p>39.2.7.улс төрийн нам, эвсэл, холбоо, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>39.2.8.албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглах, аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглах;</p> <p>39.2.9.албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан илэрхий болсон, албан үүргийн дагуу олж мэдсэн төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц болон хувь хүний эмзэг мэдээллийг задруулах;</p> <p>39.2.10.удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх, мэдээлэл дамжуулах;</p> <p>39.2.11.ажил хаях, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;</p> <p>39.2.12.төрийн албан хаагчид хуулиар хориглосон бусад.</p>
	<p>8.Төрийн тусгай хамгаалалтын хүрээнд хүний эрхийг хязгаарлах болон албадлага хэрэглэх</p> <p>Зургадугаар бүлэг. 48 дугаар зүйл.Биеийн хүч, зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой хэрэглэх нийтлэг үндэслэл</p>

	<p>үндэслэл, журмыг “гарцаагүй нөхцөлд зохистой байдлыг харгалzan зөвхөн хуулиар тогтоох” Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан өөрчилнө.</p>	<p>48.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэж болно.</p> <p>48.2.Галт зэвсэг, тусгай хэрэглэх сургалтад хамрагдан, эрх олгогдсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, хэрэглэх эрхтэй.</p> <p>48.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг өөрийн дотоод итгэлээр үнэлж, биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгслийг сонгон хэрэглэх эрхтэй.</p> <p>48.4.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх галт зэвсэг, сум, тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх бэлтгэл хангах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.</p> <p>48.5.Төрийн тусгай хамгаалалтад биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.</p> <p>48.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник хэрэглэхдээ дараах нийтлэг шаардлагыг баримтална:</p> <p>48.6.1.зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх;</p> <p>48.6.2.тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх;</p> <p>48.6.3.хамгаалауулагч болон хамгаалж байгаа объектын аюулгүй байдалд заналхийлж буй нөлөөллийг бодитоор үнэлж, өөрийн дотоод итгэл үнэмшилийн дагуу хэрэглэх.</p> <p>48.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч, бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг хэрэглэнэ.</p> <p>48.8.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.</p> <p>48.9.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт тус тус нэн даруй</p>
--	--	--

	<p>мэдэгдэнэ.</p> <p>49 дүгээр зүйл. Биеийн хүч хэрэглэх</p> <p>49.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь дараах тохиолдолд биеийн хүч хэрэглэж болно:</p> <p>49.1.1. хамгаалуулагчийн зорчин явах замыг чөлөөлөх үед зайлшгүй тохиолдолд;</p> <p>49.1.2. төрийн тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүйгээр нэвтрэсэн, нэвтрэхийг завдсан;</p> <p>49.1.3. төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд саад учруулсан болон хамгаалалтын дэглэм зөрчсөн;</p> <p>49.1.4. төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг заналхийлсэн, доромжилсон, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байсан, эсэргүүцсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан;</p> <p>49.1.5. хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхийг завдсан хориглосон, хязгаарласан эд зүйлийг хураан авахад эсэргүүцэл үзүүлсэн;</p> <p>49.1.6. галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.</p> <p>50 дугаар зүйл. Тусгай хэрэгслийн төрөл</p> <p>50.1. Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх тусгай хэрэгсэл нь дараах төрөлтэй байна:</p> <p>50.1.1. нэг бүрийн;</p> <p>50.1.2. олон хүнд нөлөөлөх;</p> <p>50.1.3. бусад.</p> <p>50.2. Төрийн тусгай хамгаалалтад нисдэг тэрэг, газар уснаа явагч, тусгай хэрэгслийр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, нисэгчгүй нисэх төхөөрөмж албадан буулгах техник хэрэгсэл, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгагч болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно.</p> <p>50.3. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийгөө болон хамгаалуулагчийг хамгаалах тусгай хэрэгслийр хангагдана.</p> <p>51 дүгээр зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл</p> <p>51.1. төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:</p> <p>51.1.1. гав;</p> <p>51.1.2. хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;</p> <p>51.1.3. бороохой;</p> <p>51.1.4. цахилгаан гүйдлээр цохигч;</p> <p>51.1.5. хутга;</p> <p>51.1.6. нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;</p> <p>51.1.7. резин болон хуванцар сумтай буу;</p> <p>51.1.8. нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.</p> <p>51.2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биедээ энэ хуулийн 51.1-д заасан тусгай хэрэгсэл байхгүй тохиолдолд гарцаагүй байдал, аргагүй хамгаалалт болсон үед гарын доорх эд зүйлийг тусгай хэрэгслийн</p>
--	---

	<p>зориулалтаар ашиглаж болно.</p> <p>52 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх</p> <p>52.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно:</p> <p>52.1.1.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хүч хэрэглэн эсэргүүцсэн;</p> <p>52.1.2.түр saatuuлагдсан этгээд өөрийгөө гэмтээх нэхцэл байдал үүссэн, тухайн этгээдийг зэвсэг хэрэглэн суллахаар завдсан буюу халдсан, хэрэглэсэн эсхүл бүлэглэн довтолсон үед;</p> <p>52.1.3.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хүч хэрэглэн хууль бусаар нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;</p> <p>52.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;</p> <p>52.1.5.хамгаалауулагч болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн биед халдсан буюу халдахыг завдсан;</p> <p>52.1.6.хамгаалауулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд зэвсгийн чанартай зүйл хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;</p> <p>52.1.7.олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.</p> <p>53 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл</p> <p>53.1.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:</p> <p>53.1.1.олон хүнд нөлөөлөх нулиms асгаруулагч, амьсгал боогдуулагч;</p> <p>53.1.2.усан хөөрөг;</p> <p>53.1.3.утаан хөшиг үүсгэгч;</p> <p>53.1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.</p> <p>54 дүгээр зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх</p> <p>54.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн хамгаалалтыг удирдаж байгаа албан тушаалтын шийдвэрээр олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэнэ.</p> <p>54.2.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:</p> <p>54.2.1.төрийн тусгай хамгаалалтын бүсэд үүссэн эмх замбараагүй байдлыг өөр аргаар таслан зогсоох боломжгүй үед;</p> <p>54.2.2.хамгаалауулагч, төрийн тусгай хамгаалалтын авсан барилга, бусад зүйл руу бүлэглэн довтолсон үед таслан зогсоохор, бүслэн хаалтаас чөлөөлөх үед;</p> <p>54.2.3.галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай бодис, нулиms асгаруулагч, амьсгал боогдуулагч хий болон хүний эрүүл мэндэд сэргөөр нөлөөлөх химиин бодис зэрэг зүйлсээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ</p>
--	--

	<p>хураалгах шаардлагыг эсэргүүцсэн үед;</p> <p>54.2.4.галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.</p> <p>55 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл</p> <p>албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх</p> <p>55.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд тээврийн хэрэгсэл албадах зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэнэ:</p> <p>55.1.1.автотээврийн хэрэгсэл ашиглан хамгаалуулагч болон хамгаалалтад авагдсан барилга, бусад зүйл рүү довтолсон;</p> <p>55.1.2.тээврийн хэрэгслээр төрийн тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;</p> <p>55.1.3.төрийн тусгай хамгаалалтын бүсэд автотээврийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглаан хийж нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;</p> <p>55.1.4.автотээврийн хэрэгслийг зогсоо талаар өгсөн ойлгогдохуйц дохио, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн;</p> <p>55.1.5.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг барьцаалан тээврийн хэрэгсэл ашиглан зугтаасан.</p> <p>55.2.Автотээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх боломжгүй тохиолдолд автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж болно.</p> <p>55.3.Автотээврийн хэрэгслийг албадан зогсоосны улмаас учирсан хохирлыг тухайн автотээврийн хэрэгслийг жолоодож явсан хүн хариуцана.</p> <p>56 дугаар зүйл.Нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэх</p> <p>56.1.Төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг зөвшөөрөлгүй нисгэсэн тохиолдолд албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэж буулгана.</p> <p>56.2.Албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэсний улмаас учирсан хохирлыг тухайн нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэсэн этгээд хариуцана.</p> <p>57 дугаар зүйл.Албаны нохой ашиглах</p> <p>57.1.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд албаны нохой ашиглаж болно.</p> <p>57.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөрийн болон хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг хориглоно.</p> <p>57.3.Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.</p> <p>58 дугаар зүйл.Галт зэвсэг хэрэглэх үндэслэл</p> <p>58.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:</p>
--	---

		<p>58.1.1.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйл, үүргээ гүйцэтгэж байгаа төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид галт зэвсэг хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;</p> <p>58.1.2.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар халдсан буюу халдахаар завдсан этгээдийн үйлдлийг өөр аргаар таслан зогсоох боломжгүй;</p> <p>58.1.3.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх.</p> <p>58.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон;</p> <p>58.1.5.хамгаалуулагчийн болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах.</p> <p>58.2.Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулитын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно.</p> <p>59 дүгээр зүйл.Галт зэвсэг хэрэглэх</p> <p>59.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийг шууд хэрэглэж болно. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.</p>
--	--	---

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл Долоон бүлэг, 60 зүйлтэй./

3.3. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл Долоон бүлэг, 60 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэсэг
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшиүүлсэн зорилго, зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28-32 дугаар зүйл, Хууль

		нь хамруулах	тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3.	Харилцан уялдаа	Хуулийн зохицуулалтыг төслийн бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үзүүлэх аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд томъёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ. Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн “Хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүлэх” үндсэн зорилгод хүрэх хүрээнд тавьсан зорилтуудыг хангахад чиглэсэн эсэх, хангах боломжтой байдлаар томьёологдсон эсэхэд үнэлгээ хийлээ.

4.1.1.Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтыг зорилго, хамрах хүрээ, хамгаалалтын арга хэлбэр болон баримтлах зарчим зэргийг харилцан уялдаатай байдлаар төрийн бусад хамгаалалтаас ялган тодорхойлж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгана.” 1 дүгээр зорилтын хүрээнд хуулийн төслийн 4, 5 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

5 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалт

5.1.Төрийн тусгай хамгаалалт нь хамгаалуулагч болон хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж байгаа эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хамгаалалт, үйлчилгээ, техник, технологийн болон бусад арга хэмжээний цогц байна.

5.2.Төрийн тусгай хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд төрийн хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагын хэвийн, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг хангахад чиглэсэн тусгай албаны үйл ажиллагаа мөн.

5.3.Төрийн тусгай хамгаалалтыг ил болон далд хэлбэр, тусгай арга, хэрэгслээр зохион байгуулна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсон “төрийн хамгаалалт, түүний онцлог” болон мөн хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд хамгаалалтыг хэрэгжүүлэх хүрээ буюу хамгаалалтад авах албан тушаалтан болон объектийг тодорхойлох нөхцөл, шалгуурыг ойлгомжгүй, хоёрдмол утгатай, өөр хоорондоо зөрчилтэй байдлаар хуульчилсан байсан. Тухайлбал, хуулийн 6.1.5-д “Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн гадны өндөр, дээд хэмжээний зочин” төрийн тусгай хамгаалалтад байхаар зохицуулсан нь “өөрийн хамгаалалттай ирсэн бүх зочид төлөөлөг”-ийг Монгол Улсын төрийн

тусгай хамгаалалтад авах мэт зөрүүтэй байдлыг үүсгэхээр, мөн хуулийн 6.3-т төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэнийг тогтоох шалгуурыг хэт ерөнхий буюу “Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс” гэж тодорхойлсон, 7 дугаар зүйлд заасан төрийн тусгай хамгаалалтаар хангах олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн гэдэгт ямар арга хэмжээг хамааруулах нь тодорхойгүй зэрэг хийдлийг арилгах шаардлагатай байгаа болно.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд төрийн тусгай хамгаалалтыг олон улсын нийтлэг жишиг, орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн томъёолж төрийн тусгай хамгаалалтын зорилго, хэлбэр, арга хэрэгслийг тодорхой зааж өгч “төрийн тусгай хамгаалалт” гэсэн суурь ойлголтыг ойлгомжтой, тодорхой болгосноор дээр дурдсан хийдлийг арилгах боломжтой болгожээ.

Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн болон хуулийн төсөлд шинэчлэн тусгасан байдлаар харьцуулан харуулж байна:

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулаг/-ийн төсөл
4 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зарчим Төрийн тусгай хамгаалалт нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, иж бүрэн байх зарчимд үндэслэнэ.	4 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын зарчим 4.1. Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана: 4.1.1. хууль дээдлэх; 4.1.2. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх; 4.1.3. улс төрөөс ангид байх; 4.1.4. нууцыг чанд хадгалах; 4.1.5. иж бүрэн байх; 4.1.6. тасралтгүй байх; 4.1.7. шинжлэх ухааны болон орчин үеийн техник, технологийн ололтыг ашиглах; 4.1.8. хамтран ажиллах.

Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд улс төрөөс ангид байх, тасралтгүй байх, шинжлэх ухааны болон орчин үеийн техник, технологийн ололтыг ашиглах, хамтран ажиллах зарчмуудыг оруулж ирсэн нь төрийн тусгай хамгаалалтад гарцаагүй баримтлах ёстой хэм хэмжээ байна гэж үзлээ.

Дээрх хуулийн төслийн зохицуулалтууд нь үндсэн зорилгод хүрэх 1 дүгээр зорилтыг хангасан гэж үзэхээр байна.

4.1.2. Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тусгай албаны хувьд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг шинэчилж, хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбар болон төрийн байгууллага хооронд уялдуулан зохицуулах чиг үүргийг тусган өргөжүүлж, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хуульчилна” 2 дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн 18, 27, дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

18 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллага
18.1. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлнэ.
18.2. Төрийн бусад байгууллагууд чиг үүрэг, энэ хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж оролцно.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн З дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалт ньмэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн.”, 10 дугаар зүйлийн 1-д “Төрийн тусгай хамгаалалтын байгууллага /цаашид “Төрийн тусгай хамгаалалтын газар” гэх/ нь төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.” гэж тус тус заасан байх ба З дугаар зүйлд заасан “мэргэжлийн байгууллага” гэдгийг тодорхойлоогүй, “бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор” гэдгээс төрийн тусгай хамгаалалтыг бусад байгууллага хэрэгжүүлдэг гэж заасан атлаа 10 дугаар зүйлд төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага гэж заасан нь хуулийн дотоод зохицуулалтууд өөр хоорондоо зөрчилдсөн байдлыг үүсгэж байна. Иймд төрийн тусгай хамгаалалтыг ямар байгууллага хэрэгжүүлэх, бусад байгууллагууд ямар оролцоотой байхыг тодорхой болгосон зохицуулалт болсон байна.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулаг/-ийн тесел
<p>11 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын газрын эрх, үүрэг</p> <p>1.Төрийн тусгай хамгаалалтын газар дараах эрх эдлэнэ:</p> <p>1/төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын төв, орон нутгийн байгууллагаас туслалцаа авах, харилцан ажиллах;</p> <p>2/төрийн тусгай хамгаалалтын бус, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох журам, дэглэм тогтоох, хяналт тавих;</p> <p>3/хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор төр, захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас хамгаалалтын ажлын нөхцөл байдалтай холбогдох мэдээ, судалгаа гаргуулж авах;</p> <p>4/хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;</p> <p>5/энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт нисэх онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уул тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн шалгалт хийхэд алба хаагчаа байлуулах;</p> <p>6/хамгаалуулагчид дотоод, гадаадаас ирүүлсэн бэлэг дурсгал, бусад зүйлд тэсэрч</p>	<p>27 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын бүрэн эрх</p> <p>27.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>27.1.1.төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулах;</p> <p>27.1.2.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;</p> <p>27.1.3.төрийн тусгай хамгаалалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;</p> <p>27.1.4.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр арга зүйгээр хангах, чиглүүлэх, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>27.1.5.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;</p> <p>27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхдэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээлэлээр шуурхай хангагдах, дүн шинжилгээ хийх;</p> <p>27.1.7.төр, орон нутгийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;</p> <p>27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;</p> <p>27.1.9.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхдээ тухайн аюулгүй байдлыг хангах нөхцөл, хэрэгцээ, шаардлагыг харгалzan энэ хуульд заасны дагуу төрийн тусгай</p>

<p>дэлбэрэх, хордуулах бодис байгаа эсэхэд мэргэжлийн болон холбогдох байгууллагаар шалгалт, шинжилгээ хийлгэх;</p> <p>7/хамгаалуулагчийн хоол, хүнсний бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, үйлчилгээнд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үзлэг, шалгалт хийж, дүнг холбогдох байгууллагад мэдэгдэх;</p> <p>8/гадаад орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.</p> <p>9/хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхим, хамгаалуулагчийн ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл болон түр байрлах орон байр, албан тасалгаанд техникийн үзлэг, шалгалт хийх.</p>	<p>хамгаалалтын бус, хамгаалалтын дэглэм тогтоох, хяналт тавих;</p> <p>27.1.10.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;</p> <p>27.1.11.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэрэгээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;</p> <p>27.1.12.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;</p> <p>27.1.13.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бусад радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;</p> <p>27.1.14.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан ажиллах;</p> <p>27.1.15.төрийн байгууллагын төвлөрсөн болон бусад мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;</p> <p>27.1.16.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг далдлахын тулд өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;</p> <p>27.1.17.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;</p> <p>27.1.18.гадаад орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;</p> <p>27.1.19.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;</p> <p>27.1.20.хуульд заасан бусад.</p>
---	---

Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг Засгийн газрын тохируулагч агентлагийн эрх хэмжээнд нийцүүлэн шинэчилж, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан өөрчлөх шаардлага үүсээд байсан. 2020 онд Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь Засгийн газрын тохируулагч агентлаг болж өөрчлөн байгууллагдсан ч байгууллагын эрх зүйн байдлыг Засгийн газрын

агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд бүрэн нийцүүлээгүй хариуцсан чиглэлийн бодлогыг тодорхойлж хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбар болон төрийн байгууллага хооронд уялдуулан зохицуулах чиг үүргийг тусгаагүй нь төрийн тусгай хамгаалалтын бодлого нэгдсэн байхад хүндэр үүсгэх нөхцөл байдал болж байна. Иймд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тусгай албаны хувьд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг шинэчилж, хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого тодорхойлж, Засгийн газрын тохируулагч агентлагийн түвшинд болгон өргөжүүлэн хуульчилсан нь зорилтыг хангахад чиглэсэн гэж үзлээ.

Хуулийн төслийн 18, 27 дугаар зүйлийн зохицуулалтууд нь үндсэн зорилгод хүрэх 2 дугаар зорилтыг хангасан гэж үзэхээр байна.

4.1.3.Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшиүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтад байх этгээд, объектыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн хуульчилна” З дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн 6, 10 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуульд заасны дагуу тусгай хамгаалалтад авах албан тушаалтан, хүн, объекттой холбоотой шийдвэрийг Засгийн газраас гаргаж байгаа боловч хамгаалалтад авах үндэслэл болон шалгуур тодорхойгүйгээс хамгаалалтад авах объектыг цаг үеийн шинжтэй нөхцөл байдал, хүчин зүйлийг харгалзан харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж байна.

Иймд тусгай хамгаалалтад хамруулах албан тушаалтан, хүнийг хуулиар тодорхой зааж өгөх болон хамгаалалтад авах объектыг тогтоох үндэслэл, журмыг хуулиар тодорхой болгож хамгаалалтыг хуульд заасан үндэслэлээр нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төсөлд тусгажээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл
<p>6 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн</p> <p>1.Дараах албан тушаалтан, иргэн төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>1/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;</p> <p>2/Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч;</p> <p>3/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэнийг хуульд заасан хугацаанд;</p> <p>4/Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг сонгуулийн компани эхэлсэн өдрөөс сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд, Улсын Их Хурлын даргад болон Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг нэр дэвсэн өдрөөс албан ёсны шийдвэр гарах хүртэлх хугацаанд;</p> <p>5/Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин.</p> <p>2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хамгаалуулагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан түүний эхнэр / нөхөр / , насанд хүрээгүй хүүхдийн амь биед гадны аюул учирч болзошгүй тохиолдолд тухайн нөхцөл байдал</p>	<p>6 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, хүн, хамгаалалтад байх хугацаа</p> <p>6.1.Дараах албан тушаалтан, хүн төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>6.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;</p> <p>6.1.2.Монгол Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч;</p> <p>6.1.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч;</p> <p>6.1.4.Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч;</p> <p>6.1.5.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүн;</p> <p>6.1.6.Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, парламентын дарга, тэдгээрийг дагалдан явaa эхнэр /нөхөр/;</p> <p>6.1.7.Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад орны дэд ерөнхийлөгч, гадаад хэргийн сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, гадаад улсын төр, засгийн газрын тэргүүний бие төлөөлөгч, гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнж.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан хамгаалуулагч</p>

<p>арилах хүртэл тэднийг төрийн тусгай хамгаалалтад түр хугацаагаар авч болно.</p> <p>3.Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад албан тушаалтан, иргэнийг төрийн тусгай хамгаалалтад хамааруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.</p>	<p>дор дурдсан хугацаанд төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>6.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хугацаанд;</p> <p>6.2.2.энэ хуулийн 6.1.2-т заасан хүн Монгол Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэх хугацаанд;</p> <p>6.2.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч хуульд заасны дагуу түүнийг нэр дэвшсэн талаар нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд;</p> <p>6.2.4.Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч нэр дэвшсэн өдрөөс албан ёсны шийдвэр гарах хүртэлх хугацаанд;</p> <p>6.2.5.Монгол Улсын Ерөнхийлөгч асан хүн бүрэн эрхийнх нь хугацаа дууссанаас эхлэн 3 жил, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүн бүрэн эрхийнх хугацаа дууссанаас эхлэн 2 жилийн хугацаанд;</p> <p>6.2.6.энэ хуулийн 6.1.6, 6.1.7-д заасан зочин Монгол Улсад айлчлах хугацаанд.</p> <p>6.3.Энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан түүний эхнэр /нөхөр/, 18 насанд хүрээгүй хүүхдийн амь биед гадны аюул учирч болзошгүй тохиопдолд тухайн нөхцөл байдал арилах хүртэл тэднийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтад түр хугацаагаар авч болно.</p>
<p>7 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх хурал, чуулган, бусад арга хэмжээ</p> <p>1.Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөлгөөн төрийн тусгай хамгаалалтад байна.</p> <p>2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хурал, чуулган бусад арга хэмжээ явагдаж байгаа танхим, түүний орчинд эрх бүхий байгууллагаас тогтоосон дэг журам зөрчихийг хориглоно.</p> <p>8 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх барилга, тээврийн хэрэгсэл, бусад зүйл</p> <p>1.Төрийн тусгай хамгаалалтад дараах барилга, тээврийн хэрэгсэл байна:</p> <p>1/Монгол Улсын Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц, төрийн харш, гадаадын дээд, өндөр хэмжээний зочдын байрлах зочид буудал;</p> <p>2/хамгаалуулагчийн хөлөглөж яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэл.</p> <p>2.Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай бусад зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.</p>	<p>10 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх объект</p> <p>10.1.Дараах хуралдаан төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>10.1.1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаан;</p> <p>10.1.2.Засгийн газрын хуралдаан;</p> <p>10.1.3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан.</p> <p>10.2.Доор дурдсан барилга байгууламж, нутаг дэвсгэр төрийн тусгай хамгаалалтад байна:</p> <p>10.2.1.Монгол Улсын Төрийн ордон;</p> <p>10.2.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын ажлын байр, зориулалтын орон сууц, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр;</p> <p>10.2.3.төрийн тусгай хамгаалалтын зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа барилга байгууламж, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр.</p> <p>10.3.Хамгаалуулагчийн хөлөглөн яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэл төрийн тусгай хамгаалалтад байна.</p> <p>10.4.Олон улсын дээд хэмжээний хурал, уулзалт, хэлэлцээг төрийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Засгийн газар тухай бүр шийдвэрлэнэ.</p> <p>10.5.Энэ хуульд зааснаас бусад объектыг төрийн тусгай хамгаалалтад авах, хамгаалалтаас гаргах асуудлыг энэ хуулийн</p>

	5.2-т заасныг болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.
--	---

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д “Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн гадны өндөр, дээд хэмжээний зочин” төрийн тусгай хамгаалалтад байхаар зохицуулсан нь “өөрийн хамгаалалттай ирсэн бүх зочид төлөөлөгч”-ийг Монгол Улсын төрийн тусгай хамгаалалтад авах мэт зөрүүтэй байдлыг үүсгэхээр, мөн хуулийн 6.3-т төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэнийг тогтоох шалгуурыг хэт ерөнхий буюу “Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс” гэж тодорхойлсон нь тухайн албан тушаалтан, хүнийг ямар шалгуур үзүүлэлтээр хэн тогтоож төрийн тусгай хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэх вэ гэдгийг тогтоож өгөөгүйгээс уг зохицуулалтын хэрэглээнд гажуудал үүсгэдэг.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т “хуульд зааснаас гадна төрийн тусгай хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай бусад зүйлийн жагсаалтыг Засгийн газраас тогтоохоор заасны дагуу 1995 онд Засгийн газрын 127 дугаар тогтоолоор хуульд заасан Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууцнаас гадна Их тэнгэрийн ам, Их тэнгэрийн амны гүүр, Төрийн тусгай хамгаалалтын газрын гарааш, хүнсний агуулах зэрэг объектуудийг төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоож байсан бол Засгийн газрын 2012 оны 65 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан жагсаалтын дагуу Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь яам, агентлаг, орон нутгийн захирагааны байгууллага, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар зэрэг 28 төрлийн барилга, байгууламжийг хамгаалалтаар хангах болжээ.

Ийнхүү 1995 онд тогтоосон төрийн тусгай хамгаалалтад байх объектыг хэт өргөжүүлж, 7 дахин нэмэгдүүлсэн нь төрийн тусгай хамгаалалтын үндсэн чиг үүрэгт хамаарах биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахын зэрэгцээ тусгай хамгаалалтын ач холбогдол, мэргэшсэн байх чадварыг бууруулж, харуул хамгаалалтын чиг үүрэгтэй адилтган үзэхэд хүргэсэн байна.

Түүнчлэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар тогтоосон төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бусад хуулиар өргөжүүлэн тогтоодог хуулийн гажуудал бий болж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд Төрийн тусгай хамгаалалтын байгууллага Эрдэнэсийн санг гэрээний үндсэн дээр хамгаалах, Эрдэнэсийн сангийн эрдэнэсийг тээвэрлэх, шилжүүлэх, байршуулах үйл ажиллагааг хариуцах шинэ чиг үүргийг оруулжээ.

Дээр дурдсан хууль хэрэгжилтийн хүрээнд үүсээд байгаа гажуудал нь хуулийн зохицуулалтын хийдэлтэй байдал буюу төрийн тусгай хамгаалалтын зорилго, онцлог, хамрах хүрээг төрийн бусад төрлийн хамгаалалтаас зааглан тодорхойлж чадаагүй, хамгаалалт тогтоох шалгуурыг хэт ерөнхий тогтоосон зэрэг нь хамгаалалтад авах объектыг тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байдлаар тогтоох нөхцөлийг бүрдүүлжээ.

Иймд дээрх хуулийн зохицуулалтын өөрчлөлт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн холбогдох зохицуулалтын хэрэглээний гажуудлыг арилгаж ойлгомжтой, тодорхой, нэг мөр хэрэгжих боломжийг бүрдүүлж хуулийн төслийн үндсэн зорилгод хүрэх 3 дугаар зорилтыг хангасан байна.

4.1.4.Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын бүс”-ийг албан тушаалтан, хүн, барилга, байгууламж, хуралдаан зэрэг хамгаалалтын объектын онцлогийг харгалзан ялгамжтай байдлаар тогтоож хуульчилна.” 4 дүгээр зорилтын хүрээнд хуулийн төслийн 11 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал:

11 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын бүс

- 11.1.Хамгаалуулагчийн болон төрийн тусгай хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын бүс тогтооно.
- 11.2.Төрийн тусгай хамгаалалтын бүсийг байнгын болон түр байна.
- 11.3.Төрийн тусгай хамгаалалтын байнгын бүсийг дараах байдлаар тогтооно:

 - 11.3.1.энэ хуулийн 10.1, 10.5-д заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага;
 - 11.3.2.энэ хуулийн 10.2-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг тухайн объектод хамаарах нутаг дэвсгэрийн хязгаараар;
 - 11.4.Төрийн тусгай хамгаалалтын түр бүсийг дараах байдлаар тогтооно:

 - 11.4.1.энэ хуулийн 7.4-т заасан барилга байгууламж, орон байр, нутаг дэвсгэрийн төрийн тусгай хамгаалалтын бүсийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч;
 - 11.4.2.энэ хуулийн 10.4-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6-д “төрийн тусгай хамгаалалтын бүс” гэж гадуур хамгаалалт зохиож байгаа болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, нутаг дэвсгэрийг тус тус хэлнэ” гэж зааснаас өөрөөр төрийн тусгай хамгаалалтын бүсийг хэн, хэрхэн тогтоохыг зааж өгөөгүй хийдлийг арилгаж хуулийн төслийн 3.1.3.-д хамгаалалтын бүсийг тодорхойлж, төслийн 11 дүгээр зүйлд хамгаалалтын бүсийг байнгын болон түр болгон ангилж, хэн, юуг үндэслэж тогтоохыг тодорхой зааж өгсөн байгаа нь хуулийн төслийн үндсэн зорилгод хүрэх 3 дугаар зорилтыг хангасан байна.

4.1.5.Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, төрийн бусад байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг шинэчилнэ” 5 дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн 18, 21, 22, 23, 25 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

18 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллага

- 18.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлнэ.
- 18.2.Төрийн бусад байгууллагууд чиг үүрэг, энэ хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж оролцно.

21 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын үүрэг

- 21.1.Төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйлийг галын аюулаас хамгаалж, гамшиг, онцгой байдлын үед Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй.

21.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлнэ.

- 21.3.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл.Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- 22.1.Хамгаалуулагчийн эрүүл мэндийг онцлон хамгаалах үүрэгтэй.
- 22.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 22.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл.Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг

23.1.Хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчинд болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг тогтмол тавьж, Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр лабораторийн шинжилгээ хийх бөгөөд холбогдох мэдээ, мэдээллээр Төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг шуурхай хангах үүрэгтэй.

23.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

23.3.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхдэд хүний хүлээх үүрэг

25.1.Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хуульд нийцүүлэн тавьсан хүсэлт, шаардлагыг биелүүлж, бүхий л бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 5 дугаар бүлэгт “Төрийн тусгай хамгаалалтын талаар тагнуул, цагдаа болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэний хүлээх үүрэг”-ийг зааж өгснийг хэвээр үлдээж, харин төрийн тусгай хамгаалалтад байнга дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг зарим байгууллагын тухайлбал, онцгой байдал, эрүүл мэнд, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн байгууллагуудын үүргийг тодорхой зааж, хамтран ажиллаж журам баталж хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Түүнчлэн хүчин төгөлдөр хуулиар “төрийн тусгай хамгаалалтад Монгол Улсын иргэд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хүсэлт, хуульд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлж, бүхий л бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлнэ.” гэснийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн” болгон өргөжүүлж хууль хэрэглээнд гарах хийдлийг арилгасан байна.

Иймд дээрх хуулийн зохицуулалтын өөрчлөлт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн холбогдох зохицуулалтын хэрэглээний хийдлийг арилгаж ойлгомжтой, тодорхой, нэг мөр хэрэгжих боломжийг бүрдүүлж хуулийн төслийн үндсэн зорилгод хүрэх 5 дугаар зорилтыг хангасан байна.

4.1.6.Хуулийн төслийн үндсэн зорилтыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, алба хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллах эрх зүйн үндэслэлийг тогтооно.” 6 дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн 33, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл
13 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч 1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь төрийн тусгай албан хаагч мөн. 2.Төрийн тусгай хамгаалалтын албанад 20 наас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг ажиллуулна. 3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ.	33 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч 33.1.Энэ хуульд заасан тангараг өргөж, төрийн тусгай хамгаалалтын албанад томилогдон ажиллаж байгаа төрийн тусгай албан хаагчийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ. 33.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, төрийн тусгай хамгаалалтын албанад болон мэргэжлийн чиглэлээр

<p>4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална.</p>	<p>ажилласан жил зэргээс бүрдэнэ.</p>
<p>5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газар батална.</p>	<p>33.3.Төрийн тусгай хамгаалалтын албанц ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тогтооно.</p>
<p>16 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа</p>	<p>33.4.Энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийн шадар хамгаалалтад хамгаалалтын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдаж шадар хамгаалалтын ажилтны нөөцэд бүртгэлтэй төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг томилно.</p>
<p>1.Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.</p>	<p>33.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.</p>
<p>2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг захирах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.</p>	<p>33.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад шаардлагатай мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан дотоод, гадаадын боловсролын байгууллагад сурган, томилж болно.</p>
<p>3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдуулэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын газрын даргад мэдэгдэнэ.</p>	<p>33.7.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үйлчилгээний албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой харилцааг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.</p>
<p>4.Гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул учирч болзошгүй бодитой нөхцөл байдал бий болсон тохиолдолд тэдгээрийг хамгаалалтад авч болно.</p>	<p>33.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдэлнэ.</p>
<p>5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-т заасан цалин, нэмэгдлээс бүрдэнэ.</p>	<p>40 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн баталгаа</p>
<p>6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албан хаасан хугацааны болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p>	<p>40.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшилаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.</p>
<p>7.Төрийн тусгай хамгаалалтын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газар тогтооно.</p>	<p>41 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн улс төрийн баталгаа</p>
<p>8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.</p>	<p>41.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.</p>
<p>9.Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шэнийн зээлжид ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг төрийн тусгай хамгаалалтын газар хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.</p>	<p>41.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг энэ хуулийн 41.1-д заасан үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.</p>
<p>10.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.</p>	<p>42 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хууль зүйн баталгаа</p>
<p>11.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.</p>	<p>42.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг шууд удирдах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, албан үүргээ гүйцэтгэж байхад нь саатуулах, бие, эд зүйлд нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.</p>
<p>12.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн</p>	<p>42.2.Төрийн тусгай хамгаалалтын алба</p>

<p>тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.</p>	<p>хаагчийг албан тушаалын чиг үүрэгт нь нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.</p>
<p>13.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.</p>	<p>42.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргад мэдэгдэнэ.</p>
	<p>42.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Монгол Улсын Ерөнхий сайдад, бусад алба хаагчийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.</p>
	<p>42.5.Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.</p>
	<p>42.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэнээс бусдад учирсан хохирлыг төр хариуцна.</p>
	<p>42.7.Эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, үүрэг даалгаврыг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ёсчлон биелүүлснээс үүссэн үр дагаврыг тушаал, үүрэг даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.</p>
	<p>42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.</p>
	<p>42.9.Энэ хуулийн 42.8-д зааснаас гадна дор дурдсан нөхцлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:</p>
	<p>42.9.1.байгууллагын захиалгаар дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцах;</p>
	<p>42.9.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох.</p>
	<p>42.10.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцна.</p>
	<p>42.11.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг гүйцэтгэх ажлын зорилгоор ашиглахыг хориглоно.</p>
	<p>42.12.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгднө.</p>
	<p>43 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаа</p>
	<p>43.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь наасаа алдсан тохиолдолд 10 жилийн албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг түүний гэр бүлд нэг удаа олгоно.</p>
	<p>43.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад гэмт халдлагын</p>

улмаас эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлгэсэн иргэний урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан амь насанд нь хохирол учруулсны улмаас нас барсан бол энэ хуулийн 43.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.

43.3. Энэ хуулийн 43.1-д заасан тэтгэмжийн зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

43.4. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөн олговор, тусламж олгоно:

43.4.1. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор;

43.4.2. хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

43.4.3. хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

43.5. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрт энэ зүйлийн 43.4.3-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

43.6. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.7. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

43.8. Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлгэсэн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

43.9. Энэ хуулийн 43.4-т заасан нөхөн олговор, тусламж олгох журам, 43.8-д заасан зардал олгох журмыг Засгийн газар батална.

43.10. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтын албанд ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.

44 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эдийн засгийн баталгаа

44.1. Засгийн газар төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

44.2. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг төрөөс орон сууцаар хангана.

44.3. Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжинд ажиллах үед хоол, унааны зардал, хээрийн сургууль, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг

	<p>Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.</p> <p>44.4. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд суралцагч төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн суралцах хугацааны сургалтын зардал, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.</p> <p>44.5. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс нь дараах цалин, нэмэгдлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> 44.5.1. албан тушаалын үндсэн цалин; 44.5.2. цэргийн цолны цалин; 44.5.3. төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл; 44.5.4. албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл; 44.5.5. мэргэшлийн зэргийн нэмэгдэл; 44.5.6. эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл; 44.5.7. хуульд заасан бусад. <p>44.6. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн тусгай алба хаасан хугацааны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>44.7. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цэргийн цолны цалингийн хувь хэмжээг цэргийн цолны цалингийн хэмжээ тогтоосон хууль тогтоомжид зааснаар тооцно.</p>
--	---

Одоо хучин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль нь 1995 онд батлагдсан бөгөөд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавих шаардлага, эрх зүйн баталгаатай холбоотой зохицуулалт нь төрийн албаны эрх зүйн шинэчлэлээс хоцорсон төдийгүй сонгон шалгаруулах, томилох журмыг улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчимд нийцүүлэн нарийвчлан зохицуулах шаардлага тулгарч байсан тул Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт болон Төрийн албаны эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлж хуулийн төслийн үндсэн зорилгод хүрэх 6 дугаар зорилтыг хангасан байна.

4.1.7. Хуулийн төслийн үндсэн зорилтыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр “төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, алба хаах насны дээд хязгаарыг тогтоох, цэргийн цол хэрэглэх”-тэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж дүгнэсний дагуу хуулийн зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн шинэчилж, хууль хоорондын хийдэл, цоорхойг арилгана. 7 дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн 35, 36, 39 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдал:

35 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, албаны үнэмлэх

35.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан

дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

35.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загвар, өмсөх дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

35.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад цэргийн цол хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хуульд заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

36 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах нас

36.1.Ажлын шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан энэ хуульд заасан шаардлагыг хангасан 35 хүртэлх насын иргэнийг төрийн тусгай хамгаалалтын албанд томилж цэргийн цол олгож болно.

36.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насын дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хуульд заасан ахлагчийн болон офицерийн алба хаах насын дээд хязгаартай адилтган тооцно.

36.3.Алба хаах насын дээд хязгаарт хурсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

36.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насын дээд хязгаарт Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насын хязгаар хамаарахгүй.

39 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавих ёс зүйн тусгай шаардлага

39.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрийг бусад алба хаагч биелүүлэх үүрэгтэй. Удирдах албан тушаалтны шийдвэр хууль тогтоомж болон энэ хуулийн 39.2-т нийцсэн байна.

39.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараах зүйлийг хориглоно:

39.2.1.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах;

39.2.2.албан тушаал, байгууллагын нэр болон хамгаалуулагчийн нэр төрийг хувийн болон улс төрийн зорилгоор ашиглах;

39.2.3.хамгаалуулагч, түүний гэр бүл, дотны хүмүүст хувийн хүсэлт тавих, бусдын хүсэлтийг дамжуулах;

39.2.4.албан үүргээ гүйцэтгэх болон албаны бэлэн байдал зарласан үед, ажлын байранд болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

39.2.5.мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;

39.2.6.хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хэвлэн нийтлэх;

39.2.7.улс төрийн нам, эвсэл, холбоо, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;

39.2.8.албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглах, аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглах;

39.2.9.албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан илэрхий болсон, албан үүргийн дагуу олж мэдсэн төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц болон хувь хүний эмзэг мэдээллийг задруулах;

39.2.10.удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусад мэдээлэх, мэдээлэл дамжуулах;

39.2.11.ажил хаях, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

39.2.12.төрийн албан хаагчид хуулиар хориглосон бусад.

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг ч цэргийн алба хаагч биш тусгай албаны ажилтан тул эрх зүйн байдлын энэ онцлогтой уялдуулан цэргийн цол хэрэглэх, төрийн тусгай хамгаалалтын алба хаах насыг тусгайлан тогтоож эрх зүйн байдлыг нэг мөр ойлгох боломжийг бүрдүүлсэн байна. Мөн Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д нийцүүлэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хуулиар тогтоосон байна.

Эдгээр зохицуулалт нь хуулийн төслийн зорилгын 7 дугаар зорилтыг бүрэн хангасан байна гэж үзлээ.

4.1.8.Хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын хүрээнд хүний эрхийг хязгаарлах болон албадлага хэрэглэх үндэслэл, журмыг “гарцаагүй нөхцөлд зохистой байдлыг харгалзан зөвхөн хуулиар тогтоох” Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан

өөрчилнө.” 8 дугаар зорилтын хүрээнд хуулийн төслийн Зургадугаар бүлэг /48-59 дүгээр зүйл/-т дүн шинжилгээ хийсэн байдал:

Зургадугаар бүлэг

48 дугаар зүйл.Биесийн хүч, зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой хэрэглэх нийтлэг үндэслэл

48.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэж болно.

48.2.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамрагдан, эрх олгогдсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, хэрэглэх эрхтэй.

48.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан нэхцэл байдал үүссэн тохиолдолд тухайн нэхцэл байдлыг өөрийн дотоод итгэлээр үнэлж, биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгслийг сонгон хэрэглэх эрхтэй.

48.4.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх галт зэвсэг, сум, тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх бэлтгэл хангах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

48.5.Төрийн тусгай хамгаалалтад биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

48.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник хэрэглэхдээ дараах нийтлэг шаардлагыг баримтална:

48.6.1.зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

48.6.2.тухайн нэхцэл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх;

48.6.3.хамгаалулагч болон хамгаалж байгаа объектын аюулгүй байдалд заналхийлж буй нөлөөллийг бодитоор үнэлж, өөрийн дотоод итгэл үнэмшилийн дагуу хэрэглэх.

48.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч, бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг хэрэглэнэ.

48.8.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биесийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.

48.9.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт тус тус нэн даруй мэдэгдэнэ.

49 дүгээр зүйл.Биесийн хүч хэрэглэх

49.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь дараах тохиолдолд биесийн хүч хэрэглэж болно:

49.1.1.хамгаалулагчийн зорчин явах замыг чөлөөлөх үед зайлшгүй тохиолдолд;

49.1.2.төрийн тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүйгээр нэвтрэсэн, нэвтрэхийг завдсан;

49.1.3.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд саад учруулсан болон хамгаалалтын дэглэм зөрчсөн;

49.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг заналхийлсэн, доромжилсон, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байсан, эсэргүүцсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан;

49.1.5.хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхийг завдсан хориглосон, хязгаарласан эд зүйлийг хураан авахад эсэргүүцэл үзүүлсэн;

49.1.6.галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

50 дугаар зүйл.Тусгай хэрэгслийн төрөл

50.1.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх тусгай хэрэгсэл нь дараах төрөлтэй байна:

50.1.1.нэг бүрийн;

50.1.2.олон хүнд нөлөөлөх;

50.1.3.бусад.

50.2.Төрийн тусгай хамгаалалтад нисдэг тэрэг, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, нисэгчгүй нисэх төхөөрөмж албадан буулгах техник хэрэгсэл, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгач болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно.

50.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийгөө болон хамгаалулагчийг хамгаалах тусгай хэрэгслийн хангагдана.

51 дүгээр зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл

51.1.төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:

51.1.1.гав;

- 51.1.2.хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;
- 51.1.3.бороохой;
- 51.1.4.цахилгаан гүйдлээр цохигч;
- 51.1.5.хутга;
- 51.1.6.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- 51.1.7.резин болон хуванцаар сүмтай буу;
- 51.1.8.нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.
- 51.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биедээ энэ хуулийн 51.1-д заасан тусгай хэрэгсэл байхгүй тохиолдолд гарцаагүй байдал, аргагүй хамгаалалт болсон үед гарын доорх эд зүйлийг тусгай хэрэгслийн зориулалтаар ашиглаж болно.
- 52 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх**
- 52.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно:
- 52.1.1.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хүч хэрэглэн эсэргүүцсэн;
- 52.1.2.түр саатуулагдсан этгээд өөрийгөө гэмтээх нөхцөл байдал үүссэн, тухайн этгээдийг зэвсэг хэрэглэн суллахаар завдсан буюу халдсан, хэрэглэсэн эсхүл бүлэглэн довтолсон үед;
- 52.1.3.төрийн тусгай хамгаалалтын бусэд хүч хэрэглэн хууль бусаар нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;
- 52.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;
- 52.1.5.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн биед халдсан буюу халдахыг завдсан;
- 52.1.6.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд зэвсгийн чанартай зүйл хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;
- 52.1.7.олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.
- 53 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл**
- 53.1.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:
- 53.1.1.олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;
- 53.1.2.усан хөөрөг;
- 53.1.3.утаан хөшиг үүсгэгч;
- 53.1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.
- 54 дүгээр зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх**
- 54.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн хамгаалалтыг удирдаж байгаа албан тушаалтын шийдвэрээр олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэнэ.
- 54.2.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:
- 54.2.1.төрийн тусгай хамгаалалтын бусэд үүссэн эмх замбараагүй байдлыг өөр аргаар таслан зогсоох боломжгүй үед;
- 54.2.2.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтын авсан барилга, бусад зүйл руу бүлэглэн довтолсон үед таслан зогсоохоор, бүслэн хаалтаас чөлөөлөх үед;
- 54.2.3.галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай бодис, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хий болон хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх химийн бодис зэрэг зүйлсээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг эсэргүүцсэн үед;
- 54.2.4.галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.
- 55 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх**
- 55.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд тээврийн хэрэгсэл албадах зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэнэ:
- 55.1.1.автотээврийн хэрэгсэл ашиглан хамгаалуулагч болон хамгаалалтад авагдсан барилга, бусад зүйл рүү довтолсон;
- 55.1.2.тээврийн хэрэгслийн төрийн тусгай хамгаалалтын бусэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;
- 55.1.3.төрийн тусгай хамгаалалтын бусэд автотээврийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглаан хийж нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;
- 55.1.4.автотээврийн хэрэгслийг зогсоох талаар өгсөн ойлгогдохуйц дохио, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн;
- 55.1.5.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг барьцаалан тээврийн хэрэгсэл ашиглан зугтаасан.
- 55.2.Автотээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх боломжгүй тохиолдолд автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж болно.

55.3. Автотээврийн хэрэгслийг албадан зогсоосны улмаас учирсан хохирлыг тухайн автотээврийн хэрэгслийг жолоодж явсан хүн хариуцана.

56 дугаар зүйл. Нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэх

56.1. Төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг зөвшөөрөлгүй нисгэсэн тохиолдолд албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэж буулгана.

56.2. Албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэсний улмаас учирсан хохирлыг тухайн нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэсэн этгээд хариуцана.

57 дугаар зүйл. Албаны нохой ашиглах

57.1. Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд албаны нохой ашиглаж болно.

57.2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөрийн болон хамгаалулагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг хориглоно.

57.3. Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

58 дугаар зүйл. Галт зэвсэг хэрэглэх үндэслэл

58.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

58.1.1. хамгаалулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйл, үүргээ гүйцэтгэж байгаа төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид галт зэвсэг хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;

58.1.2. хамгаалулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар халдсан буюу халдахаар завдсан этгээдийн үйлдлийг өөр аргаар таслан зогсоох боломжгүй;

58.1.3. хамгаалулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх.

58.1.4. төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн галт зэвсгийг булаачаар довтолсон;

58.1.5. хамгаалулагчийн болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах.

58.2. Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусlamж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно.

59 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх

59.1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийг шууд хэрэглэж болно. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Дээрх зохицуулалтууд нь төрийн тусгай хамгаалалтын хүрээнд Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас хүний эрхийг хязгаарлах болон албадлага хэрэглэх үндэслэл, журмыг “гарцаагүй нөхцөлд зохистой байдлыг харгалзан зөвхөн хуулиар тогтоох” Үндсэн хуулийн зарчимд нийцүүлсэн, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг ялгаатай байдлаар хуульчлан тогтоож төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглах боломжийг бүрдүүлэн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулсан буюу төслийн үндсэн зорилгыг хангах 8 дугаар зорилтыг бүрэн хангасан байна.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, 31 дүгээр зүйлд заасан хуулийн төсөлд товчлол хэрэглэх, 32 дугаар зүйлд заасан хуулийн төсөлд эшлэл хэрэглэх шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай <u>ялдсан</u> байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан. Хүлээлгэх хариуцлагын төрөл хэмжээг энэ хуулийн төсөлд тусгахгүй бөгөөд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинчилсэн найруулгын төслийг дагаж Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль болон Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд

	өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийж журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг нийт 16 хуулийн төслийг боловсруулсан болно.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбаргаар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

Хуулийн төсөлд товчлол хэрэглээгүй байх ба эшлэлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн хэрэглэсэн байна.

4.3.“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах”шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн	Шаардлага хангасан.

	болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	
4	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй гэж үзлээ.
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тусгасан байна.
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардуулан тусгаагүй гэж үзсэн.
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжгүй.
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Татвар хураамж тогтоогоогүй.
11	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь авлига, хүнд бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Шаардлага хангасан.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний судалгааны тайлан”-2022 он;

2. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, дагаж гарах 16 хуулийн төсөл;
3. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он;
4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;
5. Төрийн тусгай хамгаалалтын газраас хийсэн “Гадаад орнуудын төрийн хамгаалалтын байгууллагуудын судалгаа”.-2020 он

5.2. Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчид болон ахмад ажилтнуудын санал, гадаад улс орнуудын төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэсэн.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

5.2.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Хуулийн төслийн зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг төслийн зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томьёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн зохицуулалтууд нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэлийг хангалттай хэмжээнд илэрхийлж чадсан байна.

Түүнчлэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг шинэчилэн найруулах шаардлагатай эсэхийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн, ойлгомжтой байдлаар тодорхойлсон гэж дүгнэв.

Хуулийн төслийн сонгож авсан зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалт тодорхойлсон үндсэн зорилго, зорилтыг бүрэн илэрхийлж, үүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж чадсан эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн холбогдох зохицуулалтуудыг сонгон авч тухайн асуудалд хамааралтай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тулгуурлан үнэлгээг хийлээ.

Хуулийн төслийн 4, 5 дугаар зүйлд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтыг

зорилго, хамрах хүрээ, хамгаалалтын арга хэлбэр болон баримтлах зарчим зэргийг харилцан уялдаатай байдлаар төрийн бусад хамгаалалтаас ялан тодорхойлж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгана.” 1 дүгээр зорилтыг хангасан байна.

Хуулийн төслийн 18, 27 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийснээр “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тусгай албаны хувьд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг шинэчилж, хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбар болон төрийн байгууллага хооронд уялдуулан зохицуулах чиг үүргийг тусган өргөжүүлж, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн хуульчилна” 2 дугаар зорилтыг хангасан байна

Хуулийн төслийн 6, 10 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтад байх этгээд, объектыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн хуульчилна” 3 дугаар зорилтыг хангасан байна гэж дүгнэлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын бүс”-ийг албан тушаалтан, хүн, барилга, байгууламж, хуралдаан зэрэг хамгаалалтын объектын онцлогийг харгалзан ялгамжтай байдлаар тогтоож хуульчилна.” гэсэн 4 дүгээр зорилтыг хангасан байна.

Хуулийн төслийн 18, 21, 22, 23, 25 дугаар зүйлүүдэд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, төрийн бусад байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг шинэчилнэ” гэсэн 5 дугаар зорилтыг хангасан байна.

Хуулийн төслийн 33, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, алба хаагчдыг тогтворт суурьшилтай ажиллах эрх зүйн үндэслэлийг тогтооно.” гэсэн 6 дугаар зорилтыг хангасан байна.

Хуулийн төслийн 35, 36, 39 дүгээр зүйлүүдэд дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр “төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, алба хаах насны дээд хязгаарыг тогтоох, цэргийн цол хэрэглэх”-тэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж дүгнэсний дагуу хуулийн зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн шинэчилж, хууль хоорондын хийдэл, цоорхойг арилгана.” гэсэн 7 дугаар зорилтыг хангасан байна.

Хуулийн төслийн Зургадугаар бүлэг /48-59 дүгээр зүйл/-т дүн шинжилгээ хийснээр хуулийн төслийн үндсэн зорилгыг хангахаар дэвшүүлсэн “Төрийн тусгай хамгаалалтын хүний эрхийг хязгаарлах болон албадлага хэрэглэх үндэслэл, журмыг “гарцаагүй нөхцөлд зохистой байдлыг харгалзан зөвхөн хуулиар тогтоох” Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан өөрчилнө.” гэсэн 8 дугаар зорилтыг хангасан байна.

Дээрх зорилтуудын дүгнэлтийг нэгтгэж Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл нь үзэл баримтлаа лаар тодорхойлсон "Хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохисч байгуулалтыг эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүчэх" гэсэн үндсэн зорилгод хүрсэн гэж дүгнэлээ.

5.2.2. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууг ыд заасан хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн байна.

5.2.3. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нэлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг тухайн хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилгод нийцүүлж боловсруулсан, хуулийн төслийн зүйл, заалт хоорондоо болон бусад хуулийн заалттай нийцсэн, давхардаагүй, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй, болгоход чиглэсэн зохицуулалтыг тусгаагүй байна гэж үзсэн.

5.3. Зөвлөмж

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг "Хууль тогтоомжийн төслийн үр нэлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.